

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/40/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.21 № 46

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд сургалт сурталчилгаа хийж ажилласны үр дүнд Хятад улс руу нэмэлтээр мах, нүүрс нийлүүлж, экспортын хэмжээ нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А705 тушаалаар 636,935.7 мянган төгрөгийн өртөтэй шилэн кабелийн шугамыг "Мэдээлэл холбоо сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 61 хөтөлбөр, 4 зорилт, 146 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 145 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 0 хувь буюу нийт дүнгээр 90 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Гаалийн ерөнхий газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас 82.6 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

0702900227

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотроод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	22,198.5	31,060.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,321,136.4	1,568,161.6
Нийт хөрөнгийн дүн	2,343,334.9	1,599,221.8
Нийт өр төлбөрийн дүн		
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,343,334.9	1,599,221.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,343,334.9	1,599,221.8
Үйл ажиллагааны орлогын дүн	1,370,456.42	892,863.46
Үйл ажиллагааны зардлын дүн	720,603.1	886,838.50
Үйл ажиллагааны үр дүн	569,501.36	-136,901.13
Үйл ажиллагааны бус үр дүн		607,212.02
Үйл ажиллагааны нийт үр дүн	569,501.36	-744,113.16
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,366,983.6	2,343,334.9
Тайлант оны үр дүн	593,150.0	-744,113.2
Эцсийн үлдэгдэл	2,343,334.9	1,599,221.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	725,240.9	892,747.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	666,441.9	879,988.96
Үйл ажиллагааны ЦМГ	58,799.0	12,759.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	58,799.0	12,759.0
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-58799.0	-12,759.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	886,838.5	820,101.01
Урсгал зардал	886,838.5	820,101.01
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	886,838.5	820,101.01
Улсын төсвөөс санхүүжих	886,838.5	820,101.01
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 2,405.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 2,405.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар,

энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 3,342.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,342.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэр, 3,342.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй.

5.2 Албан шаардлага

1 Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай зардлын төлөвлөлтийг бодитой хийгээгүйгээс эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаал "Эдийн засгийн ангилал ашиглах заавар" 210604 Урсгал зардал /байгууллагын өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэлд урсгал шинжтэй засвар хийх зориулалтаар бэлтгэсэн материал, сэлбэг, засвар, үйлчилгээний ажлын хөлсөнд энд хамаарна/" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Байгууллагын үйл ажиллагаанд худалдан авсан 3,342.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бөөн дүнгээр нэг удаагийн шаардах хуудсаар зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Анхан шатны маягтыг зааврын дагуу бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын өмнөх онуудын мөнгөн гүйлгээний журналаас түүвэрлэн үзэхэд 2021 онд 12,173.6 мянган төгрөг, 2022 онд 5,113.6 мянган төгрөг, 2023 онд 7,514.7 мянган төгрөгийн автомашины сэлбэгийн зардал гарсан байна. Үүнээс автомашины дугуй авахад өмнөх онд 3,200.0 мянган төгрөг, тайланд онд 4,100.0 мянган төгрөгийн зарцуулсан нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2-т "Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж

ажиллахыг автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөсүгэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар нормыг тогтоож, шаардлагатай сэлбэг эд ангийг техникийн комисс томилж, дүгнэлт гаргаж зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү